

бий болгоно.



Хөдөө аж ахуйн парк болох мал аж ахуйн нэгдсэн паркийг бий болгохоор төлөвлөж судалгаа, мэдээлэл цуглуулж байна.

ОРОН НУТГИЙГ ЗОРИН ИРЭХ ИРГЭДЭД ЯМАР БОЛОМЖ НӨХЦӨЛ ОЛГОХ ВЭ?

Шилжин ирж байгаа үйлдвэр, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулах сонирхолтой иргэдэд олон улсын зам дагуу, төмс, хүнсний ногоо, эрчимжсэн мал аж ахуй, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах сонирхолтой иргэдэд газар олгож хамтарч, дэмжиж ажиллахад бэлэн байна.

Төрийн албан хаагчдын цалингийн хувьд хөдөө орон нутагт ажилласны нэмэгдлийг улсын төсвөөс 20 хувь, орон нутгийн зүгээс 80 хүртэл хувийн нэмэгдлийг олгож байна.

Ерөнхий боловсролын сургууль нь 70 хүүхдийн хүчин чадалтай дотуур байртай бөгөөд сургуулийн өмнөх боловсрол буюу цэцэрлэг, сургуулийн хүрэлцээ хангамж сайн. Сумын Эрүүл мэндийн төвийн их засвар, өргөтгөл 2024 онд улсын төсвийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөгдсөн.



НЭЭЛТТЭЙ СЭЛЭНГЭ

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

ОРОН НУТГИЙН ОНЦЛОГ, ДАВУУ ТАЛ:

1976 оны 11 дүгээр сарын 15-нд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 249 тоот тогтоол гарснаар газар тариалангийн төв бүс болох Сэлэнгэ аймгийн Ерөөгийн САА-н Мануухайтын 2 дугаар тасгийг түшиглэн Баянхараатын САА-г байгуулснаар Жавхлант сум суурь тавигдан, 1977 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн БНМАУ-ын Ардын их хурлын Тэргүүлэгчдийн 64 дүгээр зарлигаар Баянхараатын САА-г харьяалсан Сэлэнгэ аймгийн Жавхлант сум байгуулагдсан.



99074634



<http://javkhlant.se.gov.mn>

Жавхлант сум нь Сэлэнгэ аймгийн төв хэсэгт оршдог. Улаанбаатар хотоос 278 км, Сэлэнгэ аймгийн төвөөс 75 км, Дархан-Уул аймгийн төвөөс 45 км зайд хатуу хучилттай замаар холбогдсон. Нийт 118.9 мянган га талбай газар нутагтай. Бумбат, Моностой гэсэн 2 багийн нийт 597 өрхөд нийт 2149 хүн амьдардаг.

Газар нутгийн бүтцийн хувьд уул, нуруу цайдам, ухаа толгод, тал хөндий хосолсон нутагтай. Монгол орны ойт хээрийн бүсэд багтдаг үржил шимт хөрстэй нутаг юм. Энэ газар нутаг нь үр тарианы үйлдвэрлэлийн болон малын бэлчээр, хадлан, хүнсний ногооны чиглэлээр ашиглахад нэн тохиромжтой.

Түүх дурсгалын болон байгалийн үзэсгэлэн бүрдсэн газруудтай, аялал жуулчлал хөгжүүлэх бүрэн боломжтой.

СУМЫН ХӨГЖИХ БОЛОМЖ:

Сэлэнгэ аймгийн төв хэсэг, Дархан-Уул аймагт хамгийн ойрхон байрлалтай, олон улсын зам дагуу оршиж байгаа нь үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлэх боломж хамгийн өндөр, дэд бүтэц, усан хангамж, байгаль цаг уур, хөрсний чанар сайн.

Мал аж ахуй эрхлэх, газар тариалан, төмс хүнсний ногооны тариалан эрхлэх боломжтой.

Сумынхаа нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан Цагаан нуураас дөрвөн зам хүртэлх бүс нутгийг аялал жуулчлал, эрчимжсэн мал аж ахуйн бүс нутаг болгож сумын ИТХ-аар батлуулсан.

Цагаан нуурт сумын мал аж ахуйг түшиглэсэн аялал жуулчлалын бааз, мөн Хар морьтын хөтөл орчим эрчимжсэн мал аж ахуйн төвлөрөл бий болсон. Сум орон нутгийн зүгээс энэ бүс нутгуудад газар олголт, дэд бүтцийн асуудлыг шийдсэн. 2021 онд Жавхлант сумын уулзварт аймгийн 117.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 10 мянган квт-ийн дэд станц шинээр бий болсон. 2024 оны төлөвлөлт болох Шарын голын тосгонд эрчим хүчээ татахаар төлөвлөн ажиллаж байна.

Мөн Дөрвөн зам, Ерөө гол дагуух аялал жуулчлалын кемпийн үйл ажиллагаа эрчимтэй хөгжиж байна.

Хүн амын дийлэнх иргэдийн эрхэлж буй төмс, хүнсний ногооны тариалалтыг дэмжиж 10 гаруй өрхийн “Төхөм тал ургац” нөхөрлөлд сумаас 60 га газарт услалтын систем тавьж өгсөн.

Цаашид бид хүлэмжийн аж ахуйг буюу хүлэмжийн паркийг хөгжүүлэхээр төлөвлөж байна. Мөн шинээр Шарын голын баруун талд олон улсын зам дагуу 50 га газарт төвлөрсөн услалтын систем тавиулахаар Азийн хөгжлийн банканд төслөө хүргүүлснээр дэмжигдэж төсөл хэрэгжих үе шатандаа явж байна.

Жавхлант сумаа Эко сум буюу ногоон хөгжлийн дэмжсэн

сум болгон хөгжүүлэхээр ажиллаж байна. Үүний хүрээнд Стрийм төслийг хэрэгжүүлж, төслийн хүрээнд ойн зурвас бий болгох, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх, элсний нүүдлийг зогсоох ажлууд хийгдэж байна. Энэ жилийн хувьд 5 га газарт ногоон төгөл байгуулах, орчин үеийн дэвшилтэт технологийн дагуу 3 улирлын хүлэмж, гүний худагтай, 10 мянган квт-ын цахилгааны шугамтай цогц хөрөнгө оруулалтыг бий болгосон.

Орон нутгийн иргэдийн гол амьжиргаа болсон мал аж ахуй, газар тариалан, төмс хүнсний ногооны чиглэлийн ажлуудыг бодлогоор дэмжиж, иргэд, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж байна.



ХОТ ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БҮЙ БОЛОН ХИЙХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ АЖИЛ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:

Жавхлант сумын зүүн талд томоохон суурьшлын бүс буюу хороолол бий болсон. Цаашид тухайн бүсэд дутуу байгаа газруудад газар олголт, эрчим хүч цахилгаан хангамжийн асуудал, дэд бүтцийн асуудлыг бүрэн шийдвэрлэж өгнө.

Мөн олон улсын зам дагуу Жавхлант уулзварын орчим шинэ суурьшлын бүс болгон хөгжүүлэхээр төлөвлөсний дагуу эхний ээлжинд тус хэсэгт 10 мянган квт-ын шугам татсан байгаа бөгөөд айл өрхүүдэд олгосон газруудад 04квт-ын шугам татаж, дэд бүтцийг шийдвэрлэнэ.

Сум хөгжүүлэх сангийн олгох зээлийн дүнг өндөр түвшинд болгох, орон нутагт нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн гаргах иргэн, аж ахуйн нэгжүүдийг дэмжих, төмс хүнсний ногооны дахин боловсруулах үйлдвэрүүдийг барихаар төлөвлөж байна.

Цаашлаад төмс, хүнсний ногооны хажууд жимс жимсгэнийг тариалах чиглэлээр хөгжүүлэх боломжийг